

**ХААН БАНК ХК-ИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/		
<p>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</p>		
Тайлагнах хугацаа	2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр	
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	<p>Нэр: ХААН Банк ХК УБГД: 000283102 РД: 2693321 Үнэт цаасны үсгэн тэмдэг: MN0KHAN05637 Хаяг: ХААН Банк Цамхаг, Чингисийн Өргөн Чөлөө-6, Стадион Оргил-1, Хан-Уул Дүүрэг 15-р хороо, Улаанбаатар 17010, Монгол Улс Утас: 1800-1917, 7515-3333/3221/, 7507-1917 И-мэйл: investor_relations@khanbank.com Вэбсайт: www.khanbank.com</p>	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК	
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк, санхүүгийн салбар	
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК Аудитаар бүртгүүлсэн огноо – 2010 он	
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	1,912,198,000 ширхэг энгийн хувьцаа	
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	<p>Бэлтгэсэн: Т.Буянбилэг /Хөрөнгө оруулагчдын харилцааны мэргэжилтэн, ТУЗ-ийн Ажлын алба/ Хянасан: О.Ариунтулга /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/</p>	
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан	
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН		
<i>Мянган төгрөгөөр</i>	2023 оны 12 дугаар сарын 31	2022 оны 12 дугаар сарын 31
ХӨРӨНГӨ		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,957,727,074	4,373,412,201

Монголбанкинд заавал байлгах нөөц	1,090,955,256	969,104,827
Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж	13,728,242	-
Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт	1,602,635,724	1,474,096,564
Өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт	4,970,548	4,267,181
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	47,260,829	128,660,248
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	9,016,974,855	7,411,064,009
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	283,589	283,589
Бусад хөрөнгө	107,703,252	76,361,443
Биет бус хөрөнгө	43,529,294	46,286,024
Ашиглах эрхтэй хөрөнгө	12,115,097	10,202,947
Үндсэн хөрөнгө	452,369,173	455,493,746
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	389,140	3,480,567
НИЙТ ХӨРӨНГӨ	17,350,642,073	14,952,713,346
ӨР ТӨЛБӨР		
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	228,123,208	191,080,282
Репо хэлцэл	60,182,082	367,267,329
Харилцагчдын харилцах, хадгаламж	12,378,271,995	10,930,788,356
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	5,698,552	4,896,897
Банкнаас гаргасан үнэт цаас	223,998,582	-
Зээлээр авсан санхүүжилт	2,121,721,870	1,776,932,717
Орлогын албан татварын өглөг	27,366,766	3,957,990
Хойшлогдсон татварын өр төлбөр	8,855,501	4,709,251
Түрээсийн өр төлбөр	13,036,341	11,231,249
Бусад өглөг	191,651,815	146,483,209
НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,258,906,712	13,437,347,280
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		
Энгийн хувьцаа	191,219,800	172,097,820
Нэмж төлөгдсөн капитал	164,257,808	-
Хуримтлагдсан ашиг	1,649,038,593	1,268,756,786
Бусад нөөц	87,219,160	74,511,460
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	2,091,735,361	1,515,366,066
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	17,350,642,073	14,952,713,346
ОРЛОГО ҮР ДҮНГИЙН БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН		
<i>Мянган төгрөгөөр</i>	2023	2022

Үр ашигт хүүгийн аргачлалаар тооцоолсон хүүгийн орлого	1,864,815,193	1,327,391,147
Бусад хүү болон түүнтэй адилтгах орлого	43,414,439	39,974,535
Хүүгийн зардал	(804,766,104)	(475,870,927)
Бусад хүү болон түүнтэй адилтгах зардал	(16,042,582)	(5,213,387)
Хүүгийн цэвэр орлого	1,087,420,946	886,281,368
Зээлжих эрсдэлийн сангийн зардал	(92,761,247)	(143,514,238)
Зээлжих эрсдэлийн сангийн зардлын дараах хүүгийн цэвэр орлого	994,659,699	742,767,130
Хураамж, шимтгэлийн орлого	281,634,353	263,466,643
Хураамж, шимтгэлийн зардал	(59,690,761)	(47,787,841)
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх бусад зээлийн эх үүсвэрийн өөрчлөлтөөс үүссэн олз	-	2,275,457
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн цэвэр (гарз)/олз	(12,604,013)	15,878,389
Гадаад валютын арилжааны олз	30,272,682	32,799,045
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн олз	1,429,362	6,574,939
Бусад дэлгэрэнгүй орлогоор бодит үнэ цэнийг хүлээн зөвшөөрөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтаас үүссэн цэвэр олз/(гарз)	1,746,029	(900,167)
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтаас үүссэн олз	1,133,461	-
Ашиг, алдагдлаар бодит үнэ цэнийг хэмжих өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтаас үүссэн олз	1,010,247	-
Хорогдуулсан өртгөөр хэмжих санхүүгийн хөрөнгүүдийн өөрчлөлтөөс үүссэн цэвэр олз/(гарз)	5,426,968	(7,225,649)
Ашиг, алдагдлаар бодит үнэ цэнийг хэмжих санхүүгийн хөрөнгийн гарз	-	(9,019,495)
Үйл ажиллагааны бусад орлого	3,063,375	4,317,634
Үйл ажиллагааны зардал	(502,737,833)	(412,043,205)
Бусад гарз, цэвэр дүнгээр	(2,585,247)	(269,656)
Татварын өмнөх ашиг	742,758,322	590,833,224
Орлогын албан татварын зардал	(183,975,449)	(142,061,025)
Тайлант жилийн ашиг	558,782,873	448,772,199
Бусад дэлгэрэнгүй зардал:		
<i>Ирээдүйд ашиг, алдагдалд дахин ангилагдах зүйлс:</i>		
Бусад дэлгэрэнгүй орлогоор бодит үнэ цэнийг хүлээн зөвшөөрөх өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт:		
Дахин үнэлгээний цэвэр олз/(гарз)	10,956,422	(14,032,658)
Худалдан борлуулснаас ашиг, алдагдалд дахин ангилсан цэвэр (гарз)/олз	(1,746,029)	900,167
Мөнгөн гүйлгээний хейджийн нөөц	10,253,377	(11,666,472)
Бусад дэлгэрэнгүй орлогод шууд бүртгэгдсэн орлогын татвар	(4,865,942)	6,199,740
<i>Ирээдүйд ашиг, алдагдалд дахин ангилагдахгүй зүйлс:</i>		
Бусад дэлгэрэнгүй орлогоор бодит үнэ цэнэ хэмжигдэх өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалтын олз		
Бусад дэлгэрэнгүй орлогод шууд бүртгэгдсэн орлогын татвар	415,356	1,109,972
	(103,839)	(277,492)
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого/(зардал)	14,909,345	(17,766,743)
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого	573,692,218	431,005,456

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

<i>Мянган төгрөгөөр</i>	Энгийн хувьцаа	Нэмж толөгдсөн капитал	БДОБУЦ-ээр хэмжигдэх үнэт цаасны дахин үнэлгээний нооц	Мөнгөн гүйлгээний хейджийн нооц	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан ашиг	Нийт эзэмшигчдийн өмч
2022 оны 1 сарын 1-нээр	172,097,820	-	5,564,266	(1,670,161)	90,384,720	1,018,133,731	1,284,510,376
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	-	448,772,199	448,772,199
Бусад дэлгэрэнгүй зардал	-	-	(9,016,889)	(8,749,854)	-	-	(17,766,743)
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	(9,016,889)	(8,749,854)	-	448,772,199	431,005,456
Ногдол ашиг	-	-	-	-	-	(200,149,766)	(200,149,766)
Хэрэгжсэн дахин үнэлгээний нооц	-	-	-	-	(2,000,622)	2,000,622	-
2022 оны 12 сарын 31-нээр	172,097,820	-	(3,452,623)	(10,420,015)	88,384,098	1,268,756,786	1,515,366,066
2023 оны 1 сарын 1-нээр	172,097,820	-	(3,452,623)	(10,420,015)	88,384,098	1,268,756,786	1,515,366,066
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	-	558,782,873	558,782,873
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	7,219,312	7,690,033	-	-	14,909,345
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	7,219,312	7,690,033	-	558,782,873	573,692,218
Өөрийн хөрөнгийн өөрчлөлт	19,121,980	164,257,808	-	-	-	-	183,379,788
Ногдол ашиг	-	-	-	-	-	(180,702,711)	(180,702,711)
Хэрэгжсэн дахин үнэлгээний нооц	-	-	-	-	(2,201,645)	2,201,645	-
2023 оны 12 сарын 31-нээр	191,219,800	164,257,808	3,766,689	(2,729,982)	86,182,453	1,649,038,593	2,091,735,361

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

<i>Мянган төгрөгөөр</i>	2023	2022
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Татварын өмнөх ашиг	742,758,322	590,833,224
Татварын өмнөх ашгийн цэвэр мөнгөн урсгалд тохируулсан залруулгууд:		
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	12,604,013	(15,878,389)
Хүлээгдэж буй эрсдэлийн сангийн зардал	92,761,247	143,514,238
Өмчлөх бусад хөрөнгийн бодит үнэ цэнийн бууралтаас үүссэн олз/(гарз)	4,228,559	(78,812)
Үндсэн хөрөнгийн элэгдэл	55,676,503	54,489,263
Биет бус хөрөнгийн хорогдуулалт	18,292,815	20,643,564
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	8,438,579	7,623,736
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	988,660	749,553

Биет бус хөрөнгө данснаас хассаны гарз	-	4,349,666
Үндсэн хөрөнгө борлуулсны цэвэр (олз)/гарз	(514,314)	71,960
Бусад дэлгэрэнгүй орлогоор бодит үнэ цэнэ хэмжигдэх санхүүгийн хөрөнгө борлуулсны цэвэр (олз)/гарз	(1,746,029)	900,167
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн үнэт цаас борлуулсны олз	(1,133,461)	-
Ашиг, алдагдлаар бодит үнэ цэнэ хэмжигдэх өрийн үнэт цаасны олз	(1,010,247)	-
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн өөрчлөлтөөс үүссэн цэвэр (олз)/гарз	(5,426,968)	7,225,649
Ашиг, алдагдлаар бодит үнэ цэнэ хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн гарз	-	9,019,495
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх бусад зээлийн эх үүсвэрийн өөрчлөлтөөс үүссэн олз	-	(2,275,457)
Валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн олз	(1,429,362)	(6,574,939)
Хүү болон түүнтэй адилтгах орлого	(1,908,229,632)	(1,367,365,682)
Хүү болон түүнтэй адилтгах зардал	820,808,686	481,084,314
Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ	(162,932,629)	(71,668,450)
Цэвэр (өсөлт)/бууралт:		
- Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц	(120,508,368)	(161,373,304)
- Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	(1,994,603,698)	(1,398,527,921)
- Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж	(13,300,000)	-
- Бусад хөрөнгө	(37,972,735)	(4,430,702)
- Ашиг, алдагдлаар бодит үнэ цэнэ хэмжигдэх өрийн үнэт цаас	204,952,000	121,988,100
Цэвэр өсөлт:		
- Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	36,721,366	155,142,345
- Харилцагчдын харилцах, хадгаламж	1,378,733,751	757,138,330
- Бусад өр төлбөр	38,840,691	45,389,272
Татвар болон хүүгийн зардлын өмнөх үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(670,069,622)	(556,342,330)
Хүлээн авсан хүү	1,884,182,577	1,383,136,022
Төлсөн хүү	(630,826,313)	(482,696,702)
Орлогын албан татварын төлөлт	(161,390,205)	(134,218,981)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	421,896,437	209,878,009
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Өмчийн үнэт цаасны худалдан авалт	(288,011)	-
Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтыг борлуулсны орлого	-	18,299
Бусад дэлгэрэнгүй орлогоор бодит үнэ цэнэ хэмжигдэх өрийн хэлбэрээрх үнэт цаасны худалдан авалт	(76,036,641)	(56,035,308)
Бусад дэлгэрэнгүй орлогоор бодит үнэ цэнэ хэмжигдэх өрийн хэлбэрээрх үнэт цаасны борлуулалтын орлого	146,547,043	92,355,896
Хорогдуулсан өртөгөөр хэмжигдэх өрийн хэлбэрээрх үнэт цаасны худалдан авалт	(745,055,624)	(467,570,524)
Хорогдуулсан өртөгөөр хэмжигдэх өрийн хэлбэрээрх үнэт цаас борлуулсны орлого	682,276,387	281,893,933
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	712,739	1,717,306
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	(53,739,014)	(56,926,734)
Биет бус хөрөнгийн худалдан авалт	(15,536,085)	(16,514,451)

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(61,119,206)	(221,061,583)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
РЕПО хэлцлээс орж ирсэн орлого		958,913,403	3,801,304,742
РЕПО хэлцлийн эргэн төлөлт	(1,271,488,927)		(4,071,420,232)
Зээлээр авсан санхүүжилтээс орж ирсэн орлого		957,358,478	959,412,011
Зээлээр авсан санхүүжилтийн эргэн төлөлт	(616,157,388)		(560,785,101)
Банкнаас гаргасан өрийн үнэт цаасны орлого		226,762,400	-
Түрээсийн өр төлбөрийн үндсэн төлбөрийн эргэн төлөлт	(8,410,670)		(7,633,424)
Энгийн хувьцаа гаргалт болон нэмж төлөгдсөн капитал		183,379,788	-
Төлсөн ногдол ашиг	(180,702,711)		(200,149,766)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		249,654,373	(79,271,770)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	(27,272,253)		(62,181,031)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн зээлжих эрсдэлийн сангийн зардал		1,155,522	(931,403)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр бууралт		584,314,873	(153,567,778)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,373,412,201	4,526,979,979
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		4,957,727,074	4,373,412,201
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт		
ХААН Банк ХК (“ХААН Банк”, “Банк” гэх)-ийн жилийн санхүүгийн аудитлагдсан тайлангийн 3-9 дүгээр хуудас.			
1.2.	Аудитын тодорхойлох захидал		
ХААН Банкны жилийн санхүүгийн аудитлагдсан тайлангийн 3 дугаар хуудас.			
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл		
2.1.	Үйл ажиллагааны үр дүн:		
Нийт актив:			
2023 оны жилийн эцсийн байдлаар нийт актив 17.4 их наяд төгрөгт хүрч, 2022 оны эцэстэй харьцуулахад 16 хувийн өсөлт үзүүлсэн бөгөөд энэ нь нийт банкны системийн дэх тэргүүлэх үзүүлэлт бөгөөд 2023 оны 4-р улирлаар 30.4 хувийг эзэлж байна.			
Нийт зээл:			
Нийт зээлийн багц өмнөх оны эцэстэй харьцуулахад 2023 оны 12-р сарын байдлаар нийт зээл 1,691.7 тэрбум төгрөг буюу 21.2 хувиар өсөж, 9.7 их наяд төгрөгт хүрсэн байна.			
Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө:			
ХААН Банкны нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө 13.2 хувь буюу 1.7 их наяд төгрөгөөр өсөж, 15.0 их наяд төгрөгт хүрлээ. Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 82 хувийг харилцагчаас татсан эх үүсвэр, 18 хувийг банк, санхүүгийн байгууллагаас татсан зээллэг болон бусад эх үүсвэр бүрдүүлж байна.			
Өөрийн хөрөнгө:			
Нийт өөрийн хөрөнгийн хэмжээ өмнөх оны эцсээс 38 хувь буюу 576 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 2.1 их наяд төгрөгт хүрсэн байна.			
Ашигт ажиллагаа:			

2023 онд ХААН Банк 558.8 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллалаа. Үүнээс хүүгийн цэвэр орлого 1,087 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 201.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүллээ. Активын өгөөж 3.5 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 31.7 хувьд хүрч нэмэгдлээ.

2.2. Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт

2023 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар Монголбанкны зохистой харьцаа үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ(>12%)

Нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээ өмнөх оны эцсээс 1.9 пунктээр өсөж 18.63 хувьд хүрлээ.

I зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ(>12%)

I зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ өмнөх оны эцсээс 1.9 пунктээр өсөж 18.63 хувьд хүрлээ.

Хөрвөх чадварын харьцаа(>25%)

Банкны хөрвөх чадварын харьцаа 46.5 хувь буюу зохистой харьцаа 25 хувиас дээш байх шалгуурыг бүрэн хангаж ажиллаа.

Зээлийн чанар

Чанаргүй зээлийн багц 509,98 тэрбум төгрөг буюу нийт зээлд эзлэх хувь 5.3 хувь хэвээр байна.

	2022	2023
Ашигт ажиллагаа		
Өөрийн хөрөнгийн өгөөж	29.36%	31.66%
Активын өгөөж	3.37%	3.54%
Зардал орлогын харьцаа	38.05%	40.15%
Зээлийн чанар		
Чанаргүй зээлийн харьцаа	5.27%	5.29%
Зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээний харьцаа	135.13%	127.94%
Монголбанкны шалгуур		
Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа (>12%)	16.69%	18.63%
I-р зэрэглэл өөрийн хөрөнгийн харьцаа (>10%)	16.69%	18.63%
Хөрвөх чадварын харьцаа (>25%)	45.96%	46.54%
Нэгж гадаад валютын нээлттэй позицын харьцаа (+15%)	2.82%	-6.26%
Нийт гадаад валютын нээлттэй позицын харьцаа (+30%)	2.95%	-6.52%

2.3. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл

Макро эдийн засгийн орчны нөлөөллийн хувьд 2023 онд Ковид-19 цар тахлын нөлөө бүрэн арилж, гадаад худалдааны нөхцөл сайжирсантай холбоотой уул уурхайн салбарын сэргэлт үргэлжилж, түүнийг дагасан тээврийн салбарын сэргэлтийн нөлөөгөөр бодит эдийн засаг 7.0 хувиар өсөв. 2024 онд нүүрсний экспортын тоо хэмжээ хэвээр хадгалагдаж, Оюутолгойн зэс, алтны гарц нэмэгдэхээс гадна төсвийн зардлын тэлэлт, өрхийн хэрэглээний өсөлтөөс шалтгаалан эдийн засгийн өсөлт 6.2 хувьд хүрэхээр хүлээлттэй байна. Инфляцын төлөв байдал Монголбанкны зорилтын дээд хязгаарт тогтворжихоор байгаа тул 2024 оны 3-р сард Монголбанкны зүгээс бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж 12 хувьд хүргэсэн бөгөөд цаашид мөнгөний бодлогын төлөв үргэлжлэн зөөлрөх хүлээлттэй байна.

Үйл ажиллагааны орчны хувьд төрийн үйлчилгээний цахимжилт, цахим гарын үсгийн хэрэглээг нэмэгдэж буй зэрэг нь банкны үйл ажиллагаанд эерэг нөлөөтэй байна. Улсын дундаж цалин болон өрхийн дундаж орлого нэмэгдэж иргэдийн худалдан авах чадвар 38.4 хувиар нэмэгдсэн, цахим сүлжээ, ухаалаг гар утас хэрэглэгчдийн

тоо тасралтгүй өсөж буй нь зэрэг нь хэрэглэгчийн худалдан авалтын зан төлөвт шилжилт авчирч байна. Дэлхий нийтийн тогтвортой хөгжлийн чиг хандлагын хүрээнд ногоон ба тогтвортой хөгжлийн санхүүжилт нэмэгдэж байгаа нь банкны үзүүлэлтүүдэд мөн эерэг нөлөө үзүүлэх хандлагатай байна.

Дотоодын банкнуудын өрсөлдөөн нь цахим шилжилтийн хүрээнд явагдаж, харилцагчийн туулах замыг хялбаршуулах, цахим төлбөр тооцоог нэмэгдүүлэх, өгөгдлийн шинжилгээ тооцоолол ашиглах, үйл ажиллагааг автоматжуулах зэргээр цахим хөгжлийн трендийг дагаж байна. Банкны тухай хуулийн 2021 оны 1-р сард батлагдсан нэмэлт өөрчлөлтийн дагуу системийн Топ 5 банк болон Богд банк олон нийтэд нээлттэй хувьцаа гаргасан нь чухал нөлөөтэй байв. ББСБ болон финтек салбарын төлөөллүүд мөн даатгалын салбарын төлөөлөгчид ҮЦК-р дамжуулан компанийн нээлттэй хувьцаа санал болгохоос гадна ХБҮЦ, Бонд зэрэг бүтээгдэхүүнийг санал болгож олон нийтээс амжилттай хөрөнгө татаж байна. Энэхүү үйл явдал үнэт цаасны зах зээлийн арилжааны өсөлтөд томоохон нөлөө үзүүлэв. 2023 оны 4-р улирлын байдлаар ТОП-20 индексэд багтах ХК-уудын салбарын ангилалд банк санхүүгийн салбар 38.7 хувь 33Ү-ээр/ эзэлж байна. Системийн хэмжээний банкнуудын хувьцааны үнийн зах зээлийн үнэлгээ бусад салбараас харьцангуй тогтвортой байна.

ХААН Банкны салбартаа эзлэх хувь хэмжээний хувьд 2023 оны 12-р сарын 31-ний байдлаар системд үйл ажиллагаа явуулж буй банкнуудын нийт хөрөнгийн 30.4 хувь, нийт зээлийн 35.5 хувь, нийт хадгаламжийн 31.9 хувь, өөрийн хөрөнгийн 33.7 хувийг тус тус эзэлж нийт ашгийн 43.9 хувийг бүрдүүлсэн байна.

Бүтээгдэхүүний үйлчилгээний хүрээнд гарч буй өөрчлөлтүүд иргэн харилцагчийн хувьд банк доторх интернэт банк болон “Khan Bank” аппликэйшнээр хийж буй гүйлгээний хураамжийг 50 хувь буруулав. Хиймэл оюун ухаан бүхий монгол хэл дээрх чатбот туршилтаар нэвтрүүлсэн ба хиймэл оюун ухаан дээр суурилсан загвар ашиглан харилцагчийн санхүүгийн зан төлөв, амьдралын мөчлөг бүрд тохирсон бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлж байна. Түүнчлэн тэтгэврийн зээл, малчны зээлийг цахимаар авах боломжийг бүрдүүлэв. Боловсролын салбарт ажиллаж буй нийт багш нарт зориулсан тухайлсан хөнгөлөлт урамшуулалтай олон улсын картыг нэвтрүүллээ. Байгууллагын ажилтнуудад зориулсан урт хугацааны хуримтлал, хадгаламжийн үйлчилгээг шинээр үзүүлж эхлээд байна. Бизнесийн эрхлэгч нарт зориулж ПОС төхөөрөмжтэй холбоотой үйлчилгээний нэгдсэн суваг болох Мерчант Портал, 50 хүртэл сая төгрөгийн цахим бизнесийн зээлийн бүтээгдэхүүнийг тус тус нэвтрүүлэв. Мөн франчайзын зээл, ногоон төслийн бизнесийн зэргийг тус тус шинээр нэвтрүүлэв.

Өнгөрөгч онд ХААН Банк дараагийн 3 жилийн дунд хугацааны бизнесийн стратегиа тодорхойлсон. 2024 – 2026 оны банкны стратеги нь Тогтвортой Хөгжлийн бодлоготой нягт уялдаж, Тогтвортой хөгжлийн 17 зорилтыг цогцоор нь дэмжиж буй бөгөөд үйл ажиллагааны бүх чиглэлд илүү тогтвортой, хүртээмжтэй ирээдүйд үнэ цэнэ оруулахуйц зорилтуудыг дэвшүүлээд байна. 2024 оны хувьд стратегийн үндсэн 4 чиглэл болох харилцагчийн туршлага, бизнес өсөлт ба эрсдэлийн удирдлага, цахим банк, байгууллагын хөгжилд дараах зорилтуудыг дэвшүүлээд байна.

Харилцагчийн туршлага чиглэлд хялбар, шуурхай, найдвартай цахим сувгийн туршлагыг бүх сегментийн харилцагчдад хүргэж, харилцагчийн асуудлыг шийдвэрлэх хамгийн сайн процессыг олон улсын хэрэглэгчийн туршлагын стандартын дагуу хэрэгжүүлэх. Хиймэл оюунд суурилсан чатбот ашиглан харилцагчийн санал хүсэлтийг шийдвэрлэж, бүх сегментэд чиглэсэн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулж, өгөгдлийн ашиглалт, машин сургалтад суурилж харилцагчдад тохирсон бүтээгдэхүүнийг санал болгоно.

Бизнесийн өсөлтийг хангах чиглэлд хувьд хэрэглээний болон бизнесийн зээлийн багцын тэнцвэртэй өсгөх, мөн ногоон зээлийн багцыг өсөлтөд анхаарна. Эрсдэлийн удирдлагын хувьд бизнесийн үйл ажиллагаанд “СТОУС S1 & S2, ICAAP, ILAAP” зэрэг санхүүгийн болон эрсдэлийн удирдлагын олон улсын стандартыг хэрэгжүүлэх.

Түүнчлэн цахим зээлийн эрсдэл, кибер эрсдэл, уур амьсгалын эрсдэл, гуравдагч талын эрсдэл зэрэгт онцгой анхаарч ажиллахаар байна.

Цахим банкны стратегийн хувьд төлбөр тооцооны туршлагыг хялбарчилж, цахим төлбөр тооцооны дэд бүтцийг хөгжүүлэх, иргэн ба бизнесийн харилцагчдад санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх шилдэг техник технологийн үйлчилгээгээр хангах зорилттой. Түүнчлэн орчин үеийн технологийг хөшүүрэг болгож банкны хэмжээнд үйл ажиллагааны автоматжуулалтыг үргэлжлүүлж үр ашгийг нэмэгдүүлнэ.

Байгууллагын хөгжил чиглэлд ХААН Банкны тогтвортой хөгжлийн бодлогыг ТХЗ ба ҮТХН-тэй нийцүүлэн өргөжүүлж, БОНЗ-ын тэргүүлэх чиглэл ба үзүүлэлтүүдэд хэмжигдэхүйц зорилтыг тогтооно. Хүний нөөцийн үйл ажиллагааг ажилтанд үр дүнтэй хүргэж, аз жаргалтай, бүтээмжтэй ажиллах экосистемийг бүрдүүлэх, хүний нөөцийн чадавх, функцийг бий болгож байгууллагын үр ашиг, гүйцэтгэлийг сайжруулах зэрэг арга хэмжээг төлөвлөөд байна.

2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл	Жилийн санхүүгийн аудитлагдсан тайлангийн 64-69 дугаар хуудас.
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Тайлант хугацаанд буюу 2023 онд нийт 277.75 сая ам.долларын зээл авснаас эргэн төлөлт хийгээгүй болно. 2023 оноос өмнөх жилүүдэд авсан нийт зээлийн эргэн төлөлтийн дүн 93.2 сая ам.доллар болно. Зээлийн үлдэгдэл нийт 567.7 сая ам.доллар байна. Шинээр авсан урт хугацаат зээлүүд бүгд барьцаагүй зээлээр бүртгэгдсэн болно.
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл	

ХААН Банк нь сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийг холбогдох хууль тогтоомж болон ТУЗ-өөс баталсан “Ашиг сонирхлын зөрчлийн бодлого” болон “Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцлийн бодлого”-д тус тус нийцүүлэн байгуулдаг болно. (ХААН Банкны ТУЗ нь эдгээр бодлогыг 2024 оны 02 сарын 15-ны өдрийн хурлаар шинэчилэн баталсан).

Банкны холбогдох этгээд (Нэгдмэл сонирхолтой этгээд)	Активын хэлбэр	Үлдэгдэл дүн	Өөрийн хөрөнгийн эзлэх хувь
1	Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй)		
1.1	Банкны хувьцаа эзэмшигч	Зээл/баталгаа	3,566.4 0.17%
1.2	Банкны эрх бүхий албан тушаалтан	Зээл	25.0 0.001%
1.3	Банкны бусад холбогдох этгээд	Зээл/баталгаа	77,196.4 3.69%
2.	Банкны нийт холбогдол этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй)		

2.1	Банкны нийт хувьцаа эзэмшигчид	Зээл/баталгаа	167,601.4	8.01%
2.2	Банкны эрх бүхий албан тушаалтнууд	Зээл	3,719.0	0.18%
2.3	Банкны бусад холбогдох этгээд	Зээл/баталгаа	78,395.9	3.75%

ХААН Банк нь тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгээгүй болно.

4.	Цалин урамшууллын мэдээлэл
----	----------------------------

2023 онд ТУЗ-ийн гишүүдэд олгосон цалин 2,010,689,628 төгрөг, Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдэд олгосон цалин 4,884,442,875 төгрөг байна.

ХААН Банкны Хүний нөөцийн бодлогын 4 дүгээр бүлэгт цалин хөлсний бүтэц, үндсэн цалин ба түүний хэмжээг тогтоох, хэрхэн нэмэгдүүлэх талаар тусгасан. Тус бүлэгт зааснаар Монголын банкны системийн өрсөлдөөнт нөхцөл байдлыг харгалзан ХААН Банк нь бусад өрсөлдөгч банкны ажилтнууддаа олгож буй цалингийн түвшинтэй дүйцэхүйц, тэдгээрээс арай өндөр түвшинд цалин хөлс тогтоохыг эрмэлзэхээр заасан. Түүнчлэн үндсэн ажилтны цалингийн хэмжээг тогтоохдоо гадаад зах зээлийн цалингийн түвшин, албан тушаалын түвшин, зэрэглэл, ажилтны ур чадвар, мэргэшсэн байдал, гадаад хэлний мэдлэг, банкны бизнесийн хэрэгцээ, эдийн засгийн боломж болон инфляц, амьжиргааны өртгийн түвшин зэргийг харгалзан үзнэ.

5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл
----	--

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ХААН Банк ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ) нь тус Банкны хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл болон хараат бус гишүүдээс бүрдсэн нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй. ХААН Банкны ТУЗ нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Монголбанкнаас баталсан журам, заавар, ХААН Банкны Дүрэм, Компанийн засаглалын кодекс, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон бусад холбогдох эрх зүйн бичиг баримтыг мөрдөн банкны зохистой засаглалыг хэрэгжүүлэн үйл ажиллагаа явуулдаг.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн чиг үүрэг

- Банкны стратегийг тодорхойлох, хянан үзэж түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, зохион байгуулалтын бүтэц, эрсдэлийн удирдлагын бодлого, жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлах;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулах замаар асуудлыг шийдвэрлүүлэх;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлүүлэх;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувьцаа эзэмшигчдийн баталсан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувьцаа эзэмшигчдийн баталсан төрөл болон тоонд багтаан Банкны дүрэмд заасан хувьцаанд хамаарахаас бусад үнэт цаас гаргах;
- Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
- Өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах тухай шийдвэр гаргах;
- Монголбанкны Ерөнхийлөгчтэй зөвшилцөн банкны гүйцэтгэх удирдлагыг томилох, түүний бүрэн эрхийг тогтоох;

- Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх, хариуцлагыг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих, түүний цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- Банкны дотоод аудитын нэгжийг гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар зохион байгуулж, түүний төсөв, орон тоог батлах, гүйцэтгэх удирдлага, ажилтныг томилох, үйл ажиллагааны журмыг тогтоох, цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;
- Банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;
- Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлох;
- Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон банкны зохистой засаглалын бодлого, журмыг тогтоож хэрэгжилтэд хяналт тавих;
- Банкны салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;
- Банк өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал багтана.

Банкны ТУЗ-ийн гишүүн бүр Компанийн тухай хууль, Банкны тухай хуульд заасан үүргээс гадна дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- Хууль, тогтоомж болон дүрмээр олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажил, үүргээ хариуцлагатай биелүүлэх;
- Банкны эрх ашгийг хувийн болон өөрийг нь томилсон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгаас дээгүүр тавих;
- Нууцаар ашиг хүртэхгүй байх;
- Сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн үед ТУЗ-д мэдээлдэг байх;
- Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй байх;
- Банкны Гүйцэтгэх захиралд хяналт тавих, ажлын үр дүнгийн тайланг улиралд нэгээс доошгүй удаа авч хэлэлцэх, хувьцаа эзэмшигчдэд эрх тэгш хандах;
- Хувьцаа эзэмшигч, харилцагч болон хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах;
- Банкны бодлого, стратеги, эрсдэл даах сонирхлыг тодорхойлох, банканд үр ашигтай шийдвэр гаргах;
- Банкны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудит, эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналт, хууль тогтоомжийн хэрэгжилт, банкны бүтцийн өөрчлөлт зэрэг Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд хяналт тавих;
- ТУЗ-өөс Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд эрх, үүрэг, хариуцлага, үйл ажиллагаанд хяналт тавих, тайлагнах тогтолцоог бүрэн тусгаж, гэрээний биелэлтийг улирал бүр дүгнэх;
- Банкны удирдлагыг сонгон шалгаруулах, тэдгээрийн залгамж халааг бэлтгэх төлөвлөгөөг батлах, төлөвлөгөөнд удирдах дээд албан тушаал бүрд тавигдах ажил мэргэжлийн шаардлага, чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд хангалттай түвшинд бэлтгэхийг тодорхой тусгасан байх;
- Гүйцэтгэх захирлын урамшууллын асуудлыг банкны эрхэм зорилго, урт хугацааны хэтийн зорилго, стратеги төлөвлөгөө, ёс зүйн хэм хэмжээ болон гэрээнд заасан үүргийн биелэлт зэрэгтэй уялдуулан шийдвэрлэх;
- Хууль тогтоомж болон Банкны дүрмээр олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажил үүргээ хариуцлагатай, үнэнч шударгаар гүйцэтгэж, чандлан сахих;
- Ашиг сонирхлын зөрчлийн улмаас банкны өмнө хүлээсэн үүргээ зүй ёсоор хэрэгжүүлэхэд саад тотгор үзүүлэх үйлдэл, эс үйлдэл гаргахгүй байх;
- Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын стандартад заасан шаардлагыг хангасан байгууллагыг сонгон шалгаруулж, хөндлөнгийн аудит хийлгэх;
- Банкны дотоод аудитын нэгжээс хийсэн шалгалтын акт материал, ажлын тайлан зэргийг цаг тухайд нь авч хэлэлцэн, зохистой засаглал болон дотоод хяналтын тогтолцоог сайжруулах талаар Гүйцэтгэх захиралд үүрэг өгөх, авсан арга хэмжээний үр дүнг тооцох;
- Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ мэдлэг ур чадвараа дайчлан, хичээл зүтгэл гарган ажиллах.

Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Компанийн тухай хууль, Банкны тухай хуульд заасан үүргээс гадна дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан шийдвэр нь тухайн банкны эрх ашигт сөргөөр нөлөөлөх эсэхэд хяналт тавих, хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх;
- ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих;
- Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах;
- Компанийн тухай хуульд заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл, холбогдох этгээдийн хэлцэл, их хэмжээний хэлцлийг хэлэлцэхэд заавал оролцож санал өгөх;
- ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, бодлого, шийдвэр нь банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн, хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд ТУЗ-ийн хараат бус гишүүн уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлэх тохиолдолд уг асуудлыг ТУЗ-д тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг ТУЗ-д хүргүүлэх;
- Хувьцаа эзэмшигч, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, бодлого, шийдвэр нь банкны эрх ашигт сөргөөр нөлөөлөх, хууль тогтоомжийг зөрчих тохиолдол бүрд Монголбанканд мэдэгдэх, улмаар хүсэлт гарган банканд шалгалт хийлгэх;
- ТУЗ-ийн хараат бус гишүүн тус бүр нь өөрийн үндсэн үүргийн хэрэгжилт, ажлын тайлан зэргийг Монголбанканд болон хувьцаа эзэмшигчдийн хуралд жилд нэгээс доошгүй удаа тайлагнах;
- Аудитын болон Эрсдэлийн хорооны бүрэлдэхүүнд заавал орж ажиллах.

ТУЗ нь Банкны үйл ажиллагаанд дараах байдлаар оролцохыг хориглоно:

- ТУЗ-ийн гишүүн болон түүний төлөөлж буй аж ахуйн нэгж, байгууллага нь банканд зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн аливаа үүрэг, төлбөр нь чанаргүй ангилалд орсон тохиолдолд тус гишүүнийг ТУЗ-ийн хуралд саналын эрхтэй оролцуулах;
- Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох.

Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллах тохиолдолд ТУЗ-ийн үйл ажиллагаанд дараах байдлаар оролцохыг хориглоно:

- Аудитын хороо болон Эрсдэлийн хорооны бүрэлдэхүүнд саналын эрхтэйгээр орж ажиллах;
- Гүйцэтгэх захирлын бүрэн эрх, хариуцлагыг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих, түүний цалин урамшууллын хэмжээг тогтоох;
- Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ:

ХААН Банкны 2023 оны 10-р сарын 25-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 28 тоот тогтоолоор ТУЗ-ийн даргаар хатагтай Т.Дарьбум, ТУЗ-ийн дэд даргаар хатагтай Д.Хулан нарыг тус тус сонгосон.

- Т.Дарьбум – ТУЗ-ийн дарга, хараат бус гишүүн

Хатагтай Т.Дарьбум 2020 оны 8-р сараас ХААН Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр Монгол Улс болон Хойд Америкт бизнесийн удирдлага, банк санхүүгийн чиглэлээр 30 гаруй жил ажилласан, өндөр ур чадвартай мэргэшсэн хүн юм. Хатагтай Т.Дарьбум нь Хойд Америкийн зургаа дахь, Канад улсын хоёр дахь том банк болох ТиДи Банк Групп-т 10 гаруй жил ажилласан туршлагатай бөгөөд АНУ-ын Сиагтлийн Их Сургуульд санхүүгийн шинжлэх ухааны магистрын зэрэг хамгаалсан. Мэргэшсэн Нягтлан Бодогч (CPA) зэрэгтэй.

- Д.Хулан – ТУЗ-ийн дэд дарга, ТУЗ-ийн ердийн гишүүн

Хатагтай Д.Хулан нь ХААН Банкны бие даасан хувьцаа эзэмшигч төдийгүй ТУЗ-ийн гишүүнээр 2003 оны 3-р сараас эхлэн ажиллаж байна. Тэрээр Таван Богд Холдингс ХХК-ийг үүсгэн байгуулагчдын нэг бөгөөд өдгөө Таван Богд Группийн ТУЗ-ийн даргын албан тушаалыг хашдаг. Хатагтай Д.Хулан нь ОХУ-ын Москва хотын

Санхүүгийн их сургуулийн Олон улсын эдийн засгийн бакалавр, МУИС-ийн Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй, Япон улсад мэргэжил дээшлүүлж байсан. Мөн Монгол Улсын Сангийн яам, Худалдаа хөгжлийн банк зэрэг байгууллагад ажиллаж байсан, банк санхүүгийн салбарын мэдлэг, туршлагатай гишүүн билээ.

- Ханс Аарт Йонгеяанс – ТУЗ-ийн хараат бус гишүүн

Ноён Ханс Аарт Йонгеяанс нь 2020 оны 7-р сараас ХААН Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнд томилогдон ажиллаж байна. Тэрээр банк санхүүгийн салбарын эрсдэлийн удирдлагын чиглэлээр 50 гаруй жил ажилласан туршлагатай. Нидерландын Вант улсын Банк санхүүгийн институцийн дипломтой төгсөж, ЭйБиЭн АМРО Банк (Нидерланд), БиЭнПи Парибас Банк (Франц) мөн Австрали, Тайланд, Бельги, Саудын Араб, Бахрейн зэрэг улсуудын санхүүгийн байгууллагад удирдах албан тушаалд ажиллаж байсан болно.

- А.Тамир – ТУЗ-ийн хараат бус гишүүн

Монголын мэргэшсэн татварын зөвлөх, Монголын мэргэшсэн нягтлан бодогч ноён А.Тамир 2020 оны 7-р сараас ХААН Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнд томилогдон ажиллаж байна. Тэрээр аудит, нягтлан бодох бүртгэл, татварын болон санхүүгийн тайлан, дүн шинжилгээ, бизнес төлөвлөлт гэх зэргээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг олон улсын ПикЭйЭф Интернэйшнл компанийн Монгол дахь гишүүн компани болох ПикЭйЭф-АйЭфЭс Монголиа ХХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд Ерөнхий захирлын үүрэг гүйцэтгэдэг. Төрийн байгууллага болон хувийн хэвшил, олон улсын байгууллагад мэргэжлээрээ 30-аад жил ажилласан туршлагатай. А.Тамир нь Австралийн Үндэсний их сургуулийг хөгжлийн эдийн засгийн чиглэлээр төгссөн, Москва хотын Эдийн засаг, статистик болон информатикийн их сургуулийг эдийн засгийн магистрын зэрэг хамгаалсан. Ази, Номхон далайн бүсийн татварын зөвлөхүүдийн нийгэмлэгийн дэд ерөнхийлөгч бөгөөд Дэлхийн татварын зөвлөхүүдийн платформын хорооны гишүүнээр тус тус сонгогдон ажиллаж байна.

- Ц.Баатарсайхан – ТУЗ-ийн ердийн гишүүн

Ноён Баатарсайхан нь Таван Богд Холдингс ХХК-ийг төлөөлсөн ТУЗ-ийн гишүүн бөгөөд ХААН Банкны ТУЗ-ийн гишүүнээр 2009 оны 3-р сараас томилогдон ажиллаж байна. Таван Богд Холдингс ХХК-ийн үүсгэн байгуулагчдын нэг, Таван Богд Группийн Ерөнхийлөгчийн албан тушаалыг хашдаг. Ц.Баатарсайхан нь Монгол улсын Политехникийн Их Сургууль болон Япон улсын Токио хотын Цахилгаан холбооны Их Сургуулийг тус тус дүүргэсэн. Монгол-Японы хамтарсан “Алтай” ХХК-ийн захирал болон МИАТ ХК-ийн дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан туршлагатай.

- Харада Ясүнари – ТУЗ-ийн ердийн гишүүн

Ноён Харада Ясүнари Эйч Эс Интернэйшнл (Ази) Лимитед ХХК-ийг төлөөлсөн ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд Эйч Эс Холдингс ХК-ийн Ерөнхийлөгч, Төлөөлөгч Захирлын албан тушаалыг хашдаг. Тэрбээр Япон улсын Кьюшү Их сургуулийг Эрхзүйн бакалавр зэрэгтэй төгссөн. Их сургуулиа төгсмөгц тэрээр Япон улсын Аж Үйлдвэрийн банкнаас ажлын гараагаа эхлүүлсэн. Мөн тэрээр тус банкнаас гадна хөрөнгө оруулалтын банкны салбар болох Морган Стэнли, БиЭнПи Парибас энд Социэтэ Женерале зэрэг банкуудад ажиллаж байсан туршлагатай.

- Иший Кисабүро – ТУЗ-ийн ердийн гишүүн

Ноён Иший Кисабүро нь Эйч Эс Холдингс ХК-ийг төлөөлсөн ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд тус компанийн хараат бус захирлаар ажилладаг. Тэрээр Токиогийн их сургуульд эрх зүйн бакалаврын зэрэг хамгаалсан. Сургуулиа төгсмөгц ажлын гараагаа Барилгын яаманд ажилласнаар эхлүүлсэн. Тус яаманд Хотын захиргааны ерөнхий захирлаар ажиллаж байгаад Газар, дэд бүтэц, тээврийн яаманд дэд сайдын албан тушаал, Японоос Румынд суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын албан тушаал хашиж байсан.

- Жон Ло – ТУЗ-ийн ердийн гишүүн

Ноён Жон Ло нь байгууллагын банк болон хөрөнгө оруулалтын банкны чиглэлд 30 гаруй жил ажилласан арвин туршлагатай хүн юм. Өмнө нь ОУСК-ийн Олон улсын санхүүгийн зах зээлийн газарт банкны мэргэжилтнээр ажиллаж байсны дээр Ситибанк болон Жи.Пи Морган зэрэг банкуудад Ази, номхон далайн бүс хариуцан

удирдах түвшний албан тушаалууд хашиж байсан туршлагатай. Тэрбээр АНУ-ын Индиана мужийн Блүүминтон хотын Индианагийн Их Сургуульд Бизнесийн удирдлагын чиглэлээр магистрын зэрэг хамгаалсан. Ноён Жон Ло нь 2016 оноос ХААН Банк ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.

▪ Б.Амарсанаа – ТУЗ-ийн ердийн гишүүн

Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, Хууль зүйн ухааны доктор, профессор Батболдын Амарсанаа нь ХААН Банкны жижиг хувьцаа эзэмшигчдийг төлөөлсөн банкны ТУЗ-ийн ердийн гишүүн юм. Тэрээр өмнө нь арбитрын шүүхийн арбитрч, шүүн таслах бүрэлдэхүүний даргаар олон хэргүүд дээр ажиллаж байсан төдийгүй, Хонконгийн Олон улсын арбитрын төв, Олон улсын худалдааны танхимын арбитрын шүүх дээр Монгол Улсын хууль эрх зүйн мэргэжилтнээр маргаан шийдвэрлэхэд ажиллаж байсан туршлагатай. Үүнээс гадна Хууль зүйн зөвлөл (хуулийн төсөл бэлтгэх үүрэг бүхий Засгийн газрын ажлын хэсэг)-ийн үндсэн гишүүний хувьд Монгол Улсын томоохон хуулиудын төслийг бэлтгэх чиглэлээр ажилласан өргөн туршлагатай хүн юм. Мөн Монгол Улсын хууль эрх зүйн сургуулиудад зориулан Бизнесийн эрхзүйн хичээлийн хөтөлбөр (Монгол Улсын ХЗДХЯ болон Испани улсын Севиллийн их сургуулийн удирдлага дор Дэлхийн банкны хэрэгжүүлсэн Хууль, эрх зүйн шинэчлэл төсөл) боловсруулах, МУИС-ийн ХЗС-д Арилжааны тухай хууль, Арилжааны ажил гүйлгээний тухай хуулийн хичээлүүдийн хөтөлбөрийг боловсруулахад оролцсон байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь жилийн эхэнд баталсан бүтэн жилийн хуваарьт заасан өдрүүдэд улиралд нэгээс доошгүй удаагийн давтамжтайгаар ээлжит хурал хуралдуулж, өөрсдийн үүргийг хэрэгжүүлнэ.

№	Нийт гишүүдийн тоо	2023 онд хийсэн хурлын тоо	Оролцсон гишүүдийн ирц	2023 онд гаргасан тогтоолын тоо	2023 онд хийсэн хурлаар хэлэлцсэн гол асуудлууд
1.	Т.Дарьбум (дарга, хараат бус гишүүн)	8	100% (хурал тус бүр)	41	<ul style="list-style-type: none"> “ХААН Банкны олон нийтэд анх удаа хувьцаагаа арилжаалах үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний шинэчилсэн хувилбарыг баталсан. Банкны 2022 оны санхүүгийн аудитын тайлан болон жилийн үйл ажиллагааны тайлан, “ХААН Банкны тогтворжуулах төлөвлөгөө”, Гүйцэтгэх захирлын 2022 оны гүйцэтгэл, Банкны зохион байгуулалтын шинэчилсэн бүтцийг шинэчлэн баталсан. Ногоон Бондын хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг хүлээн зөвшөөрсөн. Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Банкны холбогдох дотоод дүрэм, журмуудыг шинэчлэн баталсан. ТУЗ-өөс зээлийн шийдвэрт хяналт тавих үйл ажиллагааны журмын дагуу ТУЗ-өөр хянуулан
2.	Д.Хулан (дэд дарга, ердийн гишүүн)		100% (хурал тус бүр)		
3.	Иший Кисабүро (ердийн гишүүн)		100% (хурал тус бүр)		
4.	Ясүнари Харада (ердийн гишүүн)		100% (хурал тус бүр)		
5.	Ц.Баатарсайхан (ердийн гишүүн)		100% (хурал тус бүр)		
6.	Жон Ло (ердийн гишүүн)		100% (хурал тус бүр)		

7.	А.Тамир (хараат бус гишүүн)	100% (хурал тус бүр)	шийдвэрлэх зээлийн саналуудыг хэлэлцэж баталсан. • Чанаргүй активыг холбогдох эрсдэлийн сангаас хаах, 2024 оны Дижитал стратеги”, “2024 оны Бизнес төлөвлөгөө болон төсөв/санхүүгийн төсөөлөл”, “2024-2026 оны Дунд хугацааны Тогтвортой бизнес болон Дижитал стратеги”, “2024-2028 оны Санхүүгийн төсөөлөл”, 2024 оны Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдлийг баталсан.
8.	Аарт Йонгеянс (хараат бус гишүүн)	100% (хурал тус бүр)	
9.	Б.Амарсанаа (ердийн гишүүн)	100% (хурал тус бүр)	

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД:

ТУЗ-ийн дэргэдэх Хороод тус бүрийн чиг үүрэг, үйл ажиллагаа, бүтэц бүрэлдэхүүн, гишүүдийн эрх үүрэг, тэдгээрт тавигдах шаардлага зэрэг бусад асуудлыг хороодын дүрэм, Банкны Дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар нарийвчлан зохицуулагддаг. Холбогдох журам, зааврын зохистой байдлыг хадгалах үүднээс хороод Дүрмээ хянаж, шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах саналыг ТУЗ-д хүргүүлдэг.

ХААН Банк ХК-ийн 2023 оны 10-р сарын 25-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 28 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Үүнд:

№	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороод	Хорооны дарга	Хорооны гишүүд
1	Аудитын хороо	А. Тамир (хараат бус гишүүн)	Т. Дарьбум (хараат бус гишүүн) Ханс Аарт Йонгеянс (хараат бус гишүүн) Иший Кисабүро
2	Эрсдэлийн хороо	Ханс Аарт Йонгеянс (хараат бус гишүүн)	Ц. Баатарсайхан Т. Дарьбум (хараат бус гишүүн) А. Тамир (хараат бус гишүүн)
3	Компанийн засаглалын хороо	А. Тамир (хараат бус гишүүн)	Харада Ясүнари Т. Дарьбум (хараат бус гишүүн) Ханс Аарт Йонгеянс (хараат бус гишүүн)
4	Хүний нөөцийн хороо	Д. Хулан (ТУЗ-ийн дэд дарга)	Харада Ясүнари Т. Дарьбум (хараат бус гишүүн) Б.Амарсанаа

- Аудитын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь банкны нягтлан бодох бүртгэл, дотоод аудитын үйл ажиллагаанд хяналт тавихаас гадна дүрэмд тусгагдсан бусад үүрэг, хариуцлагыг хүлээдэг. Аудитын хороо нь банкны санхүүгийн нөхцөл байдалд тогтмол хяналт тавьж, нягтлан бодох бүртгэл, комплаенс, хэрэгжилтийг хангах болон бусад хяналтын механизмын үр дүнтэй, найдвартай байдал зэрэгт дүгнэлт хийж, зөвлөмж өгдөг. Мөн банкны үйл ажиллагаа үнэн зөв, ил тод, хариуцлагатай, нээлттэй зарчмаар явж байгаа эсэхэд хяналт тавьдаг хороо юм.

№	Нийт гишүүдийн тоо	2023 онд хийсэн хурлын тоо	Оролцсон гишүүдийн ирц	2023 онд хийсэн хурлаар хэлэлцсэн гол асуудлууд
1.	А.Тамир (дарга, хараат бус гишүүн)	5	100% (хурал тус бүр)	<ul style="list-style-type: none"> Дотоод аудитын 2022 оны жилийн тайлан, 2023 оны I хагас жилийн тайлан, Дотоод аудитын 2022, 2023 оны дунд хугацааны стратегийн төлөвлөгөөний гүйцэтгэл, 2022 оны Тогтмол хугацааны бие даасан үнэлгээ болон үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан, Дотоод аудитын дүрмийн нэмэлт, өөрчлөлт, Дотоод аудитын үйл ажиллагаанд хөндлөнгийн чанарын үнэлгээ үзүүлэх байгууллагыг сонгож, төсвийг баталсан. Банкны 2022 оны аудитлагдсан санхүүгийн тайланг хянан, ТУЗ, ХЭХ-аар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Кроу хөндлөнгийн аудитын тайлангийн танилцуулгыг хэлэлцсэн. 2024 оны Дотоод Аудитын Төлөвлөгөөг баталсан.
2.	Аарт Йонгеянс (хараат бус гишүүн)		100% (хурал тус бүр)	
3.	Иший Кисабүро (гишүүн)		100% (хурал тус бүр)	
4.	Т.Дарьбум (хараат бус гишүүн)		100% (хурал тус бүр)	

- Компанийн засаглалын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Компанийн засаглалын хороо нь банкны засаглалын эрүүл соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн компанийн засаглалын цогц зарчим, ёс зүйн дүрмийг боловсруулах, ТУЗ-ийн гишүүнээр ажиллахад шаардлага хангасан этгээдийг тодорхойлох, тэдгээр этгээдийг ТУЗ-ийн гишүүнээр томилуулахаар нэр дэвшүүлэх үүднээс ТУЗ-д санал, зөвлөмж өгөх, мөн ТУЗ болон хороодын үнэлгээнд хяналт тавих үндсэн чиг үүрэгтэй юм.

№	Нийт гишүүдийн тоо	2023 онд хийсэн хурлын тоо	Оролцсон гишүүдийн ирц	2023 онд хийсэн хурлаар хэлэлцсэн гол асуудлууд
1.	А.Тамир (дарга, хараат бус гишүүн)	4	100% (хурал тус бүр)	<ul style="list-style-type: none"> 2022 оны Байгаль орчин, нийгэм, засаглалын үйл явц, хөгжлийн тайланг хэлэлцсэн. Засаглалын талаарх ТУЗ-ийн гишүүдийн сургалтыг баталсан. Банкны Тогтвортой хөгжлийн төлөвлөгөөний 2023 оны I дүгээр улирлын гүйцэтгэлийн шинэчлэл, Тогтвортой хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний явцын тайланг хэлэлцсэн. ТУЗ-ийн Ердийн гишүүнд нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах арга хэмжээний
2.	Т.Дарьбум (хараат бус гишүүн)		100% (хурал тус бүр)	
3.	Харада Ясүнари (гишүүн)		100% (хурал тус бүр)	

4.	Аарт Йонгеянс (хараат бус гишүүн)		100% (хурал тус бүр)	төлөвлөгөөг баталж, нэр дэвшүүлэх асуудлаар хэлэлцсэн. <ul style="list-style-type: none"> 2023 оны Байгаль орчин, нийгэм, засаглал/Тогтвортой хөгжлийн тайлан, 2024 оны Монголбанкны зохистой засаглалын үнэлгээний талаар хэлэлцэж баталсан.
----	---	--	--------------------------------	--

- **Эрсдэлийн хороо**

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо нь ТУЗ-д банкны эрсдэлийн түвшинг хянахад дэмжлэг үзүүлдэг бөгөөд Банкны дүрэм болон ТУЗ-ийн Эрсдэлийн хорооны дүрэмд заасан чиг үүргийн дагуу банкны эрсдэлийн ерөнхий түвшинд нийцсэн эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, түүний хэрэгжилтэд хяналт тавьж, банкны эрсдэлийн удирдлагын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлж, үнэлэлт, дүгнэлт гарган ажилладаг болно. Эрсдэлийн удирдлагын хороо, Комплаенсийн хорооноос танилцуулж буй сар бүрийн тайлан мэдээг хянаж, ТУЗ-өөс тогтоосон хүлээн зөвшөөрөх эрсдэл болон эрсдэлийн лимитийн хэрэгжилтийг баталгаажуулдаг.

№	Нийт гишүүдийн тоо	2023 онд хийсэн хурлын тоо	Оролцсон гишүүдийн ирц	2023 онд хийсэн хурлаар хэлэлцсэн гол асуудлууд
1.	Аарт Йонгеянс (дарга, хараат бус гишүүн)	4	100% (хурал тус бүр)	<ul style="list-style-type: none"> 2023 оны Банкны тогтворжуулах төлөвлөгөөг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. ХААН Банкны залилангийн эсрэг бодлого, 2022 оны II хагас жилийн тайлан, 2023 оны 5-р сарын эрсдэлийн тайлан, 2023 оны 5-р сарын комплаенсийн тайланг хэлэлцсэн. 2023 оны I хагас жилийн зээлийн тайлан, 2023 оны 3-р улирлын эрсдэлийн тайлан, 2023 оны 3-р улирлын нийцлийн тайлан, Онлайн зээлийн багцын асуудлыг хэлэлцсэн. 2024 оны “Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл”, чанаргүй активыг холбогдох эрсдэлийн сангаас хаах, 2023 оны 3-р улирлын эрсдэлийн тайлан, 2023 оны 3-р улирлын комплаенсийн тайлан, тайлан, нийт зээлийн эрсдэлийн хязгаарын гүйцэтгэлийг баталсан.
2.	А.Тамир (хараат бус гишүүн)		100% (хурал тус бүр)	
3.	Т.Дарьбум (хараат бус гишүүн)		100% (хурал тус бүр)	
4.	Ц.Баатарсайхан (гишүүн)		100% (хурал тус бүр)	

- **Хүний нөөцийн хороо**

ТУЗ-ийн дэргэдэх Хүний нөөцийн хороо нь ТУЗ-д дэмжлэг үзүүлэхээр байгуулагдсан бөгөөд ТУЗ-ийн идэвх, оролцоо болон банкны удирдах албан тушаалд ажиллах этгээдүүдийн нэрсийг дэвшүүлэх, шалгуур үзүүлэлтийг тогтоох, мэдлэг, ур чадвартай нэр дэвшигчдийг олж, тогтоон, улмаар банкны бизнесийн зорилтдоо хүрэх, бизнесээ тогтвортой хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй юм.

№	Нийт гишүүдийн тоо	2023 онд хийсэн хурлын тоо	Оролцсон гишүүдийн ирц	2023 онд хийсэн хурлаар хэлэлцсэн гол асуудлууд
---	--------------------	----------------------------	------------------------	---

1.	Д.Хулан (дарга, гишүүн)	4	100% (хурал тус бүр)	<ul style="list-style-type: none"> • 2023 оны 1-р улирлын хүний нөөцийн шинэчлэл, Банкны зохион байгуулалтын шинэчилсэн бүтцийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх, Гүйцэтгэх захирлын 2022 гүйцэтгэл, урамшууллыг баталсан. • Гүйцэтгэх захирлын гүйцэтгэл, нөхөн олговрын бүтцийн үнэлгээний талаарх “ПиДаблюСи Аудит” ХХК-ийн дүгнэлт, зөвлөмжийг баталж, тус зөвлөмжид үндэслэн хянуулсан 2023 оны Гүйцэтгэх захирлын шинэчилсэн гүйцэтгэлийн үнэлгээг баталсан. • Банкны бүх ажилтнуудын цалинг нэмэгдүүлэх саналыг хэлэлцэж баталсан. • Хүний Нөөцийн 2024-2026 оны стратеги, Гүйцэтгэх удирдлагын хороо болон Дээд Удирдлагын Залгамж Халааны Төлөвлөлт, Гүйцэтгэх захирлын 2022 оны 3-р улирлын ажлын гүйцэтгэлийн мэдээлэл, Гүйцэтгэх захирлын урамшууллын хэмжээг нарийвчлан тогтоох саналыг хэлэлцэн баталсан.
2.	Жон Ло (гишүүн)		100% (хурал тус бүр)	
3.	Т.Дарьбум (хараат бус гишүүн)		100% (хурал тус бүр)	
4.	Б.Амарсанаа (гишүүн)		100% (хурал тус бүр)	

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Тайлант хугацаанд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 3 удаа, ээлжит хурлыг 1 удаа зохион байгуулж Банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, ногдол ашиг хуваарилалт зэрэг асуудлыг хэлэлцэн баталж нийт 8 тогтоол гаргасан.

ХААН Банк нь нээлттэй хувьцаат компанийн хувиар анхдугаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг танхим болон цахимаар буюу хосолсон хэлбэрээр 2023 оны 06-р сарын 24-ний өдөр зохион байгуулсан бөгөөд энэхүү хуралд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид 86.66 хувийн ирцтэй оролцож, дараах шийдвэрүүдийг хэлэлцэн баталсан юм. Үүнд:

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ХААН Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 19,121,980,000 төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 191,219,800,000 төгрөг байхаар тогтоов.
2. ХААН Банк ХК-ийн Дүрмийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсан төслийн дагуу батлав.
3. ХААН Банк ХК-ийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд кумулятив аргаар сонгов.

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

Банкны гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-өөс томилогдсон гүйцэтгэх захирал дангаараа хэрэгжүүлнэ. Гүйцэтгэх захирал нь Банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хяналт тавина. Гүйцэтгэх захирал нь хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн гаргасан бүх шийдвэр, тогтоолын зохих хэрэгжилтийг хангана. Гүйцэтгэх захирал нь ажил үүргээ ТУЗ-тэй байгуулсан гэрээ болон холбогдох итгэмжлэлд заасан эрх хэмжээний дотор Банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах (Компанийн тухай хууль 83.1) бөгөөд Банкны гүйцэтгэх удирдлагыг Монголбанкны зөвшөөрснөөр (Банкны тухай хууль 31.3.2) ТУЗ томилж түүний үйл ажиллагаанд хяналт тавина. ТУЗ-ийн шийдвэргүйгээр ТУЗ-ийн аль нэг гишүүн, гүйцэтгэх захирлын үйл ажиллагааг хянан шалгах буюу гүйцэтгэх захиралд үүрэг, даалгавар өгөхийг хориглоно.

Гүйцэтгэх захирлын өдөр тутмын болон шуурхай үйл ажиллагаанд туслах үүрэгтэй Удирдлагын хороо ажиллана. Гүйцэтгэх захирал нь Удирдлагын хорооны гишүүдийг томилж, гишүүний эрх, үүргийг хариуцаж буй ажлын

үүрэг хариуцлага, хувь хүний ур чадвараас хамааран түүнтэй байгуулсан гэрээнд тусгаж өгнө. Удирдлагын хорооны гишүүд нь гүйцэтгэх захиралд ажлаа тайлагнана.

ХААН Банкны ТУЗ-ийн 2020 оны 12-р сарын 24-ний өдрийн 18 тоот тогтоолоор хатагтай Р.Мөнхтуяаг ХААН Банкны Гүйцэтгэх захирлаар томилсон бөгөөд тус Банкны Гүйцэтгэх удирдлагын хороо 2023 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар дараах бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Гүйцэтгэх удирдлагын хорооны бүтэц:

- Р.Мөнхтуяа – Гүйцэтгэх захирал;
- Б.Эрдэнэдэлгэр – Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч;
- Сачин Наир – Гүйцэтгэх захирлын орлогч;
- Д.Дугарбаатар – Ерөнхий аудитор;
- Д.Энхбаатар – Иргэдийн банк хариуцсан дэд захирал;
- Б.Ариунболд – Мэдээллийн технологи хариуцсан дэд захирал;
- Г.Мөнхбаяр – Эрсдэл хариуцсан дэд захирал;
- Ш.Өлзий-Аюуш – Санхүү, Захиргаа хариуцсан дэд захирал;
- Д.Ариунбат – Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал;
- Т.Ууганбаяр – Байгууллагын банк хариуцсан дэд захирал;
- Ш.Ганбямба – Хүний нөөц хариуцсан дэд захирал;
- Ч.Чинболд – Бизнес хөгжил хариуцсан дэд захирал;
- Ж.Товуудорж – Жижиг дунд бизнесийн банк хариуцсан дэд захирал;
- О.Ариунтулга – ТУЗ-ийн нарийн бичгийн дарга;

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 3-р сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийн 36 зүйлийн хэрэгжилтийн асуумжаар үнэлгээний аргачлал бүхий тайлангийн маягтын дагуу ХААН Банк нь өөрсдийн хэрэгжилтийн тайлангаа Банкны IPO-г амжилттай хэрэгжүүлснээс хойш буюу 2023 оны 6-р сарын 23-ны өдөр хүргүүлсэн. Тус хэрэгжилтийн тайлангийн дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос ХААН Банкны үнэлгээг 88.9 хувиар үнэлсэн болно. Бид тус үнэлгээг сайжруулах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөн хэрэгжүүлж байна.

ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХААН Банкны Дотоод аудит нь Ерөнхий аудиторын харьяанд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Монгол Улсын Банкны тухай хуулийн дагуу тус банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороонд шууд харьяалагдаж, Гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар зохион байгуулагдсан байдаг.

Дотоод аудит нь Дотоод аудиторуудын институт (The IIA)-аас боловсруулсан Олон улсын мэргэжлийн практикийн хүрээний заавал дагаж мөрдөх элементүүд буюу Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартууд, Ёс зүйн дүрэм, Дотоод аудитын мэргэжлийн практикийн үндсэн зарчмууд, Дотоод аудитын тодорхойлолт зэрэгт үйл ажиллагаагаа нийцүүлэн ажилладаг.

Дотоод аудитын үндсэн чиг үүрэг:

- Салбарын аудитын газар нь Иргэдийн банкны салбар, тооцооны төвүүдийн засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоо болон тэдгээрт дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Төв банкны газар, албад, зээлийн хороодын үйл ажиллагаанд аудитыг хийж гүйцэтгэнэ.
- Төв банкны аудитын газар нь Төв банкны харьяа газар, хэлтэс, алба, хороодын үйл ажиллагаа болон төсөл, хөтөлбөрүүдийн засаглал, эрсдэлийн удирдлага болон хяналтын тогтолцоонд аудитыг хийж гүйцэтгэнэ.

- Мэдээлэл технологийн аудитын газар нь банкны мэдээллийн технологи, мэдээллийн системийн үйл ажиллагаа, тэдгээрийн эрсдэлийн удирдлага, мэдээллийн аюулгүй байдлыг хамарсан аудитыг хийж гүйцэтгэнэ. Мөн Дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн систем хөгжүүлэлт, судалгаа шинжилгээ, мэдээлэл боловсруулалтыг хариуцна.

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Компанийн засаглалын кодексийн хүрээнд

ХААН Банк нь өөрийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлсээр ирсэн. Энэ талаар ХААН Банк ХК-ийн Компанийн засаглалын кодекс-т тусгаж өгсөн.

ТУЗ нь Банкны үйл ажиллагаанд оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичгийг батлах ба оролцогч талуудын ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлж, тэдгээрийг зохистойгоор тэнцвэржүүлэн ажилладаг.

Банк нь оролцогч талууд, хөрөнгө оруулагчдад өөрийн бизнес, засаглал, санхүүгийн үзүүлэлтүүд, хэтийн төлөвийн мэдээлэл болон хөрөнгө оруулагч оролцогч талуудад хамаарах санхүүгийн бус мэдээллийн ил тод байдлыг хангаж, банкны жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгаж мэдээлэл хүргүүлдэг.

- Ёс зүйн дүрмийн хүрээнд

ХААН Банкны Ёс зүйн дүрмийг 2023 онд шинэчлэн баталсан бөгөөд тус Дүрмийн 1.2-т заасны дагуу харилцагч, ажлын түнш, хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд, банкны ажилтнуудын ашиг сонирхлыг хамгаалах, тэдгээрийн хоорондын харилцааны үндсийг тодорхойлох зорилтыг хэрэгжүүлдэг болно. Ёс зүйн дүрэм нь ХААН Банкны үнэт зүйлсийн тунхаг бичигт тусгасан эрхэмлэх үнэт зүйлсийг бэхжүүлэх, харилцагч, ажил хэргийн түнш, хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд, банкны ажилтнуудын өмнө хүлээсэн, албан үүрэг, хариуцлагаа биелүүлэх, тэдний ашиг сонирхлыг хамгаалах, тэдгээрийг хоорондын харилцааны үндсийг тодорхойлох зорилтыг хэрэгжүүлнэ.

ХААН Банкны Ёс зүйн дүрмийн 6.3-т заасны дагуу Банк нь оролцогч талуудын үр дүнтэй харилцаа холбоо үүсгэх, хууль бус хөдөлмөр эрхлэлтийн эсрэг сайн туршлага хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын нэгдэн орсон НҮБ, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас баталсан Конвенц, олон улсын бусад хэм хэмжээг мөрдлөг болгон ажилладаг.

- Хөрөнгө оруулагчидтай харилцах бодлогын хүрээнд

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани болохын хувьд банк нь өөрийн удирдлага, үйл ажиллагаа, санхүүгийн байдал, цаашдын төлөв, алсын харааны талаарх мэдээллийг тодорхой, шударга, тэнцвэртэй хүргэх үүргээ хэрэгжүүлэхээр зорьж байгаа билээ. Энэ хүрээнд мөн хөрөнгө оруулагчидтай харилцах бодлогыг баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус бодлогын зорилго нь хөрөнгө оруулагчид болон боломжит хөрөнгө оруулагчдыг хөрөнгө оруулалтын тухай шийдвэр гаргахад мэдээллээр хангах, бусад оролцогчдод банк, түүний зорилгын талаар тэнцвэртэй ойлголтыг хүргэхэд банкныг шударга, үнэн зөвөөр төлөөлөх явдал юм.

Хөрөнгө оруулагчидтай харилцахдаа хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр тухайн хурлын хэлэлцэх асуудлын хүрээнд холбогдох тайлан, мэдээ мэдээллийг хэлэлцэж, санал авах, асуулга зохион байгуулж, цахимаар болон биечлэн санал, хүсэлт, өргөдөл, гомдол хүлээж авч, дээрх албан ёсны цахим хуудсууд, эсвэл биечлэн мэдээлэл хүргэж, мөн Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, зохицуулагч байгууллагаас баталсан дүрэм, журам, банкны дүрэм, болон бусад холбогдох дүрэм, журамд нийцүүлэн шаардлагатай бусад арга хэрэгслээр мэдээлэл солилцож ажилладаг.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

ХААН Банк эрсдэлийн удирдлагаа Эрсдэлийн засаглал, Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл /Risk appetite statement/, Эрсдэлийн удирдлагын үйл явц гэсэн бүрдлээр хэрэгжүүлдэг. Ингэхдээ эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо улам бэхжүүлэх, нэгдсэн байдлаар удирдах зорилгоор ISO 31000:2018 стандартыг нэвтрүүлэн ажиллаж байна.

Банкны эрсдэлийн удирдлагын гол зорилго нь Хүлээн зөвшөөрөх эрсдэл/Risk appetite/-ийн хүрээнд банкны стратеги, зорилтуудад нөлөө үзүүлж буй эрсдэлийг тодорхойлж, үр дүнтэй удирдахад оршино. Уг зорилгын хүрээнд бүх төрлийн эрсдэлүүдийн хүчин зүйлсийг тодорхойлж, түвшин бүрд тохирох арга хэмжээг авч, үр дагаврыг бууруулдаг.

6. Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл

2023 онд цар тахлын дараах эрсдэлүүд буурснаар хувийн хэрэглээ сэргэн, уул уурхайн салбар идэвхэжсэнээр Монгол улсын макро эдийн засгийн орчин тогтворжиж эхэлсэн боловч геополитикийн эрсдэлүүд, АНУ болон Европын банкнуудын дампуурал зэрэг хосолмол гадаад шокуудтай нүүр тулсан жил байлаа. Гэсэн хэдий ч банк нь зах зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд хүү, гадаад валютын ханш болон үнийн өөрчлөлт зэрэг зах зээлийн хувьсагчдын өөрчлөлтөөс шалтгаалсан банкны эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэн, ирээдүйн мөнгөн урсгалын хэлбэлзлээс хүлээж болзошгүй алдагдлыг хүлээн зөвшөөрөх эрсдэлийн түвшинд удирдаж ажиллалаа.

Банк нь гадаад валютын ханшийн хэлбэлзлээс үүсэж болзошгүй алдагдлыг тэдгээрийн эрсдэл даах чадвартай уялдуулах зорилгоор Монголбанкнаас тогтоосон тухайн нэгж болон нийт гадаад валютын нээлттэй позицын хязгаарлалтуудыг хангахын зэрэгцээ “Хамгийн их эрсдэлийн арга”-аар эрсдэлээ өдөр тутам хэмжин, удирдаж ажилладаг. Банкны гадаад валютын эрсдэлийн үнэлгээний “VaR” программ хангамж нь гадаад валютын нээлттэй позицоос хүлээх ханшийн эрсдэлийг 99 хувийн итгэх магадлалын түвшинд түүхэн эх үүсвэр, вариаци-ковариаци болон симуляцын аргачлалуудыг ашиглан тооцдог бөгөөд банк нь удирдлагын мэдээллийн систем болон эрсдэлийн үнэлгээний найдвартай, үнэн зөв бөгөөд бүрэн бүтэн байдлыг хангахад чиглэсэн стандарт тоон ба чанарын шаардлагуудад нийцүүлэн тогтмол хөгжүүлэлтүүдийг хийн ажиллалаа. Мөн банк нь гадаад валютын ханшийн эрсдэлээс хамгаалах зорилгоор урт болон богино хугацаат үүсмэл санхүүгийн хэрэгслийг ашигладаг. 2023 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар, хейджийн нягтлан бодох бүртгэлд хейджээр хамгаалагдсан зүйл гэж тодорхойлогдсон гадаадын банк болон банк бус санхүүгийн байгууллагуудаас авсан хувьсах болон тогтмол хүүтэй ам.долларын урт хугацаат зээлийн санхүүжилт нь 320,699 мянган ам.долларын нэрлэсэн дүнтэй байв.

Үүний зэрэгцээ зах зээл дэх хүүний түвшний өөрчлөлт нь богино хугацаанд банкны цэвэр хүүгийн орлогод шууд нөлөөлдөг бол урт хугацаанд өөрийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнд нөлөөлдөг. Банк нь банкны хяналт, шалгалтын Базелийн хорооноос боловсруулсан аргачлал, түүнд тодорхойлсон хүүний түвшний стандарт болон шокийн сценари хувилбаруудыг ашиглан хүүний түвшний эрсдэлээ хэмжиж, лимит тогтоох замаар сөрөг нөлөөллийг хязгаарладаг. Үүнд:

- Арилжааны бүртгэлийн хүүний түвшний эрсдэлийг хөрвөх чадвараар тохируулсан хамгийн их эрсдэлийн аргачлалд суурилан;
- Банкны бүртгэлийн хүүний түвшний эрсдэлийг орлого болон эдийн засгийн өртгийн хандлагын аргачлалуудаар хэмжиж, удирддаг.

Түүнчлэн банк нь өөрийн үйл ажиллагааны онцлог, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан үүсэж болох эрсдэлийг урьдчилан тооцож, түүнийг тэсвэрлэх хангалттай хэмжээний өөрийн хөрөнгө ба төлбөрийн чадварыг хадгалах эсвэл шаардлагатай нэмэлт нөөцийг хэрхэн бүрдүүлэх болон эрсдэлийн түвшинг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн стресс тестийн шинжилгээг улирал тутам хийж ажиллалаа.

7. Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл

ХУВЬЦАА ЭЗЭМШЛИЙН БҮТЭЦ

Банкны нийт гаргасан 1,912,198,000 ширхэг энгийн хувьцааг 2023 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар нийт 29,061 хувьцаа эзэмшигч эзэмшиж байна. Үүнд:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Улс	ХААН Банкны хувь нийлүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг
1	Эйч Эс Холдингс ХК	Япон Улс	40.99%	783,882,300
2	Эйч Эс Интернэйшнл (Ази) Лимитед ХХК	Хонг Конг, БНХАУ	8.78%	167,856,050
3	Таван Богд Холдингс ХХК ¹	Монгол Улс	22.78%	435,653,100
4	Д.Хулан (хувь хүн)	Монгол Улс	13.22%	252,738,000
5	Ажилтанд хувьцаа худалдах хөтөлбөрийн оролцогчид	Монгол Улс	4.23%	80,848,750
6	Олон нийт	Монгол Улс	10%	191,219,800
Нийт:			100.00%	1,912,198,000

¹ Таван Богд Трейд ХХК нь 2024 оны 2-р сарын 1-ний өдөр компанийн оноосон нэрийг өөрчилж Таван Богд Холдингс ХХК болсон болно.

Хувьцаа эзэмшигчдийн талаар:

Эйч Эс Холдингс ХК	Токиогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй “Эйч Эс Холдингс” ХК (ТҮО: 8699) нь санхүүгийн бизнес эрхэлдэг компаниудын хувьцааг эзэмшдэг холдинг компани бөгөөд харилцан хамаарал бүхий 7 компанитай. Эдгээр нь Gaitame.com ХХК, Эйч Эс Интернэйшнл (Ази) Лимитед, Эйч Эс Секюритис ХХК, Эйч Эс Сэрвисэр ХХК, Солид Банк ХК, ХААН Банк ХК болон Кыргызкоммерцбанк ХК зэрэг болно.
Эйч Эс Интернэйшнл (Ази) Лимитед ХХК	Эйч Эс Интернэйшнл (Ази) Лимитед компани нь Эйч Эс Холдингс ХК-ийн 100 хувийн эзэмшилтэй Хонгконг дахь охин компани юм. Тус компани нь Хятад болон Ази тивийн эдийн засгийн өсөлт дээр тулгуурлан “Эйч Эс Холдингс” ХК-ийн Ази дахь стратегийг хэрэгжүүлж, бүс нутгийн улс орнуудын зах зээлийн судалгаа хийхээс гадна Хонконгийн зах зээл дээр бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг.
Таван Богд Холдингс ХХК	Таван Богд Холдингс ХХК нь Таван Богд Группийн толгой компани ба 1997 онд Группийн бодлого стратеги, менежментийг нэгдсэн байдлаар тодорхойлох, шинэ бизнесийг нээн хөгжүүлэх, хөрөнгө оруулалт болон салбар компаниуддаа менежментийн дэмжлэг үзүүлэх зорилготойгоор байгуулагдсан. Таван Богд Групп нь худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл, аялал жуулчлал болон зочид буудал, уул уурхайн тоног төхөөрөмжийн бэлтгэн нийлүүлэлт, банк санхүү зэрэг салбарт үйл ажиллагаа явуулдаг.
Д.Хулан (хувь хүн)	Монгол Улсын иргэн Д.Хулан нь Таван Богд группийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч бөгөөд одоогоор тус группийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байна. Тэрээр ХААН Банкны ТУЗ-ийн ердийн гишүүн, ТУЗ-ийн дэд дарга бөгөөд 2010 оноос бие даасан хувьцаа эзэмшигч болсон.
Олон нийт	ХААН Банк нь Банкны тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд 2021 оны 2-р сараас эхлэн нээлттэй хувьцаат компани болох бэлтгэл ажлыг холбогдох хууль, журамд заасан хугацаанд, шат дараатайгаар хийж ирсэн бөгөөд зохицуулагч байгууллагуудаас холбогдох зөвшөөрлүүдийг хүлээн авсны дагуу анхдагч зах зээлийн арилжааны нээлтийг 2023 оны 04-р сарын 13-ны өдөр хийсэн. Банк нийт хувьцааныхаа 10 хувь буюу 191,219,800 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгосон нь Монголын хөрөнгийн зах зээлийн хамгийн өндөр дүнтэй, хамгийн олон захиалга авсан, хамгийн

	олон хөрөнгө оруулагчидтай, хамгийн хүртээмжтэй анхдагч зах зээлийн арилжаа болсон бөгөөд тус хувьцаа одоо Монголын хөрөнгийн биржид нээлттэй арилжаалагдаж байна.
Ажилтанд хувьцаа худалдах хөтөлбөрийн оролцогчид	ХААН Банкны хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 09-р сарын 30-ны өдрийн 9 тоот тогтоолоор баталсан “ХААН Банкны ажилтанд хувьцаа худалдах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зөвшөөрлийг Монголбанкнаас 2022 оны 01-р сарын 28-ны өдөр хүлээн авснаар тус Банкны 4,136 ажилтанд 80,848,750 ширхэг хувьцааг эзэмшүүлсэн. Ажилтанд хувьцаа худалдах хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Банкны ажилтан нь нээлттэй компанийн бүтэц бүхий банкныхаа бизнесийн өсөлт, ашигт ажиллагаа, нийгмийн хариуцлагыг ханган ажиллах илүү хүчирхэг бөгөөд тогтвортой хүний нөөц бүрдүүлэх давуу талтай билээ.

ГУЗ-ийн гишүүдийн хувьцаа эзэмшлийн хувь

Овог, нэр	Албан тушаал	ХААН Банк дахь (шууд) хувь эзэмшил
Т.Дарьбум	ГУЗ-ийн дарга, ГУЗ-ийн хараат бус гишүүн	0%
Д.Хулан	ГУЗ-ийн дэд дарга, ГУЗ-ийн ердийн гишүүн	13.22%
Ханс Аарт Йонгеганс	ГУЗ-ийн хараат бус гишүүн	0%
А.Тамир	ГУЗ-ийн хараат бус гишүүн	0%
Ц.Баатарсайхан	ГУЗ-ийн ердийн гишүүн	0%
Харада Ясүнари	ГУЗ-ийн ердийн гишүүн	0%
Иший Кисабүро	ГУЗ-ийн ердийн гишүүн	0%
Жон Ло	ГУЗ-ийн ердийн гишүүн	0%
Б.Амарсанаа	ГУЗ-ийн ердийн гишүүн	0.00003%

Гүйцэтгэх удирдлагын хорооны гишүүдийн хувьцаа эзэмшлийн хувь

Овог, нэр	Албан тушаал	ХААН Банк дахь (шууд) хувь эзэмшил
Р.Мөнхтуяа	Гүйцэтгэх захирал	0.09%
Б.Эрдэнэдэлгэр	Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч	0.07%
Сачин Наир	Гүйцэтгэх захирлын орлогч	0.005%
Д.Дугарбаатар	Ерөнхий аудитор	0.009%
Д.Энхбаатар	Иргэдийн банк хариуцсан дэд захирал	0.02%
Б.Ариунболд	Мэдээллийн технологи хариуцсан дэд захирал	0.009%
Г.Мөнхбаяр	Эрсдэл хариуцсан дэд захирал	0.04%
Ш.Өлзий-Аюуш	Санхүү, Захиргаа хариуцсан дэд захирал	0.01%
Д.Ариунбат	Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал	0.03%
Т.Ууганбаяр	Байгууллагын банк хариуцсан дэд захирал	0.005%
Ш.Ганбямба	Хүний нөөц хариуцсан дэд захирал	0.02%
Ч.Чинболд	Бизнес хөгжил хариуцсан дэд захирал	0.01%
Ж.Товуудорж	Жижиг дунд бизнесийн банк хариуцсан дэд захирал	0.02%
О.Ариунтулга	ГУЗ-ийн нарийн бичгийн дарга	0.001%

Тайлант хугацаанд Компанийн тухай хуульд заасны дагуу шаардах эрхээ хэрэгжүүлэн хувьцаа худалдсан хувьцаа эзэмшигч байхгүй болно.

8. Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл

ХААН Банк нь 2023 оны 04-р сарын 13-ний өдрөөс 2023 оны 04-р сарын 19-ний өдрийн хооронд олон нийтэд 959 төгрөгийн нэгж үнэ бүхий 191,219,800 ширхэг энгийн хувьцааг санал болгох замаар нийт 183,379,788,200 (Нэг зуун наян гурван тэрбум гурван зуун далан есөн сая долоон зуун наян найман мянга хоёр зуу) төгрөгийг татан төвлөрүүлсэн.

Тус Банк нь энгийн хувьцааг нийтэд санал болгон арилжсанаар өөрийн хөрөнгөө нэмэгдүүлснээс гадна татан төвлөрүүлэх хөрөнгийн 16 хувийг банкны бүтээгдэхүүн үйлчилгээний цахим шилжилтийг хурдасгах мэдээллийн технологийн хөрөнгө оруулалтад, 19 хувийг цахим бүтээгдэхүүний хөгжүүлэлт, шинэчлэлтэд, 34 хувийг ногоон төсөл хөтөлбөрүүдэд болон 31 хувийг урт хугацаатай хөрөнгө оруулалтын зээл, орон сууцны зээл санхүүжүүлэхэд зарцуулахаар төлөвлөсөн.

Мөн дунд хугацаанд харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, зайнаас хүргэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадвараа сайжруулахад чиглэсэн цахим шилжилтийн зорилтуудаа хэрэгжүүлэх, зах зээлд эзлэх байр сууриа хадгалах, тэлэх зорилтуудыг дэвшүүлсэн.

Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт 2023 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар дараах байдалтай байна. Үүнд:

№	Зарцуулалт	Эзлэх хувь	ТТХ дүн /төгрөг/	Зарцуулалт	Эх үүсвэрийн үлдэгдэл
1	Мэдээллийн технологийн хөрөнгө оруулалт	16%	29.3 тэрбум	28.1 тэрбум	1.2 тэрбум
2	Цахим бүтээгдэхүүний хөгжүүлэлт, сайжруулалт	19%	34.8 тэрбум	29.2 тэрбум	5.6 тэрбум
3	Ногоон төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилт	34%	62.4 тэрбум	51.3 тэрбум	11.1 тэрбум
4	Урт хугацаат зээл /Орон сууц, хөрөнгө оруулалтын санхүүжилт/	31%	56.9 тэрбум	56.9 тэрбум	0
	Нийт	100%	183.4 тэрбум	165.5 тэрбум	17.9 тэрбум

Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн эх үүсвэрийн үлдэгдэл 2023 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар нийт 17.9 тэрбум төгрөг байна.

9. Ногдол ашгийн мэдээлэл

ХААН Банк ХК нь Ногдол ашгийн бодлогыг Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10-р сарын 25-ны өдрийн 26 тоот тогтоолоор шинэчлэн баталсан. Ногдол ашгийн бодлогын зорилго нь Банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс баримтлах ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах нөхцөл, журмыг Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон зохицуулагч байгууллагуудаас гаргасан холбогдох дүрэм, журамд нийцүүлэн тодорхойлоход оршино. Тус Бодлогод заасны дагуу Банк нь татварын дараах цэвэр ашгийн 40 хувиас дээш хувиар ногдол ашиг хуваарилахыг эрмэлзэж ажилладаг. Зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлдэг компанийн хувьд Монголбанкнаас зөвшөөрөл олгосноор хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгаа тараах эрхтэй болдог.

ХААН Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02-р сарын 17-ны өдрийн 06 тоот тогтоолын дагуу 2022 оны татварын дараах цэвэр ашиг болох нийт 448 тэрбум төгрөгөөс банкны өөрийн эрсдэл даах чадвар, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг зохих хэмжээнд барих нөхцөлийг хангасны үндсэн дээр 1,720,978,200 ширхэг энгийн хувьцаанд 180.7 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн.

10.

Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл

ХААН Банк анх 2007 онд нийгмийн өмнө хүлээсэн үүргээ ухамсарлан ард иргэдийн сайн сайхан амьдралын төлөө бодитой хувь нэмэр оруулахаар нийгмийн хариуцлагын ажлуудыг ХААН Банк сангаараа дамжуулан бие даан хэрэгжүүлж эхэлсэн юм. ХААН Банк Сан байгуулагдсан цагаасаа хойш 510 төсөл, хөтөлбөрийг 12.7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэн, хэрэгжүүлсэн байна. ХААН Банк Сан нийгмийн хариуцлагын ажлуудаа тодорхой стратеги, төлөвлөгөөний дагуу үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс доорх 7 тэргүүлэх чиглэлд анхаарал хандуулан ажилладаг. Үүнд:

1. Хүүхэд залуусын боловсролыг дэмжих
2. Олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах
3. Байгаль орчноо хамгаалах
4. Нийгмийн эмзэг бүлгийг дэмжих
5. Орон нутгийн хөгжлийг дэмжих
6. Соёл урлагийг дэмжих
7. Тогтвортой хөгжил 17 зорилгод хувь нэмрээ оруулах юм.

2023 онд 2.7 тэрбум гаруй төгрөгийн санхүүжилтээр дараах төсөл, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүллээ. Хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн үр дүнгээс онцолбол:

- Эмэгтэйчүүдийг дэмжих хөгжлийн хөтөлбөр: ЕБС-ийн 120 эмэгтэй багшийг чадавхжуулав.
- ХААН Банкны тэтгэлэгт хөтөлбөр: 59 шинэ оюутанд тэтгэлэг олгов.
- Хавдрын эсрэг үндэсний аян: Дорнод, Увс аймагт 3052 иргэдийг үзлэг, оношилгоонд хамруулав.
- Парачи спорт: Пара спортыг дэмжин, 2 тэмцээнийг санхүүжүүлэв.
- Цусны даралт ихсэлтийн эсрэг аян: Дундговь, Өвөрхангай, Завхан, Говь-Алтай, Дархан-Уул аймагт 22,300 иргэдийг үзлэгт хамруулсан.
- Rise шинэ оюутны хөгжлийн хөтөлбөр: 800 гаруй 1-р курсын оюутнуудыг хамруулсан.
- 3x3 сагсан бөмбөгийн талбай: 15 байршилд 3x3 сагсан бөмбөгийн нөхөрсөг тэмцээн зохион байгуулсан.
- ХААН Банкны Ой: 13,900 мод, бут тарив. Мөн Тэрбум мод санд хандив өгөв.
- Компанийн нийгмийн хариуцлагын шинэ төслийн уралдаан: Ажилтнуудын дунд шинэ төслийн уралдаан зохион байгуулж, шилдэг 3 төслийг шалгаруулав.

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Р.Мөнхтуяа

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гарын үсэг: 

